



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар
тахлаас урьдчилан сэргийлэх талаар
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/161 дүгээр захирамж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, халдварын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн халдварын тархалтын улбар шар түвшинд шилжсэн хугацаанд буюу 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийг гэрээр ажиллуулсугай.

2. Цахимаар ажиллаж байгаа ажилтнуудын ажлын цагийг өдөр бүр бүртгэн даалгавар өгч биелэлтийг хангуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулж, зааварчилгаа хүргүүлэн ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан), Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА